



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хот тохижуулах албаны

2016 оны 12 дугаар сарын 31-нээр

дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2017/166/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: 0

Тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 99417382 Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930, 99932710 Цахим хаяг: kh_jenisbek@yahoo.com

Аудитор:

Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	7
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.12	Шилэн дансны мэдээлэл	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	«management_zurchil1»	Error! Bookmark not defined.
3.2	«management_zurchil2»	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16

1 Аудитын гэрчилгээ



ХОТ ТОХИЖУУЛАХ АЛБАНЫ ДАРГА
К.ЖЕНИСБЕК ТАНАА

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий сум, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: (976) 7042-2954

E-mail: bayanulgii@audit.gov.mn

2017.02.16 № 16 2017-02/16/17-1015
танай _____-ны № _____

Аудитын гэрчилгээ

Хот тохижуулах албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Баян-Өлгий аймгийн Аудитын газраас аудит хийв.

Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хот тохижуулах албаны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулга материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Gershilgee.doc

Зөрчилгүй санал дүгнэлт

Хот тохижуулах албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

Gershilgee.doc

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Хот тохижуулах албаны дарга К.Женисбек танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Хот тохижуулах албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хот тохижуулах албаны 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.02.13-наас 2017.02.16-ны хооронд хийж, аудитын тайланг 2017.02.16-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Аймгийн аудитын газрын аудитор Д.Назгүл хариуцаж хэрэгжүүлэв.

Хот тохижуулах албаны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017.01.26 - нд төрийн аудитын байгууллагад 2017.01.25-ны өдрийн 09–р албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хот тохижуулах алба нь "иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай хүргэх, хотыг цэвэр цэмцгэр байлгах" эрхэм зорилгын дор тайлант онд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

“Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилтууд дэвшүүлэн ажиллаж, чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллах”

Хот тохижуулах албаны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Хот тохижуулах алба удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь

материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Хот тохижуулах албаны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Хот тохижуулах алба санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Accolous” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Хот тохижуулах албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 65 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 5 асуудал эрсдэл өндөр, 3 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 24 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 5 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардалыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардалыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь дотоод хяналтыг хэвийн гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Хот тохижуулах албаны 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 482,5 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 9,6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь төлөвлөлтийн шатанд 2 хувийг сонгосонтой холбоотой юм.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 7 чиглэлээр 10 эрсдэлтэй асуудалд 12 хяналтын, 5 нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 20 хувь буюу 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)				
№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	0	0	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	3,0	
3	Албан шаардлага өгсөн	1	0,3	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
Дүн		1	3.3	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудал байхгүй.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Нийгмийн даатгалын шимтгэлийн ногдуулалт, төлөлтийн тооцоог шалгаж үзэхэд тайлант онд олгосон цалин, түүнтэй адилтгах орлогод 31308,6 мянган төгрөгийн шимтгэл ногдуулж, 28324,1 мянган төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлж, 2984,5 мянган төгрөгийн НДШимтгэлийг дутуу төлж, нийгмийн даатгалын санд төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйлийн 17.1.1, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.1, 14.4.3, 14.4.6 заалтуудыг тус тус зөрчсөн тул нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

ХХОАТ-ын ногдуулалт, төлөлтийн тооцоог шалгаж үзэхэд тайлант онд олгосон цалин, түүнтэй адилтгах орлогод 11347,6 мянган төгрөгийн татвар ногдуулж, 11703,9 мянган төгрөгийг шилжүүлж, 356,3 мянган төгрөгийн татварыг илүү төлсөн боловч санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй байна. Энэ нь **Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д** “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д** “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн тул албан шаардлага өгөв.

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал Холбогдох алдаа, зөрчил илэрээгүй.

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал байхгүй байна.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын тооцоо

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хот тохижуулах алба өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 236,8 сая төгрөг, хөрөнгийн зардалд 0 төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	236,9	236,3	-0.24%	-0,6
1.1	Урсгал зардал	236,9	236,3	-0.24%	--0,6
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
2	Зардлыг сахүүжүүлэх эх үүсвэр				
2.1	Орон нутгийн төсвөөс санхүүжих	236,9	236,1		
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос				

Төсөвт зардлын гүйцэтгэл 0,2 хувийн хэмнэлттэй байгаа нь төсвөө хэмнэсэнтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө өгөгдөөгүй байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 14,1 сая төгрөг зарцуулсны дотор урсгал зардалд 14,1 сая төгрөг зарцуулсан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Хот тохижуулах алба Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хот тохижуулах албаны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хот тохижуулах албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидлаар зөвлөмж өгөгдөөгүй.

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>67331639.00</u>	<u>39588092.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
33	АВЛАГА	39938775.00	0.00
335	Бусад авлага	39938775.00	0.00
3351	Байгууллагаас авах авлага	39938775.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	27392864.00	39588092.00
354	Хангамжийн материал	27392864.00	39588092.00
35410	Бичиг хэргийн материал	145000.00	80000.00
35420	Аж ахуйн материал	17041022.00	19918592.00
35430	Сэлбэг хэрэгсэл	427000.00	423000.00
35470	Бусад хангамжийн материал	9779842.00	19166500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2680506010.50</u>	<u>3041383579.47</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2680506010.50	3041383579.47
392	Биет хөрөнгө	2680506010.50	3041383579.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	121916760.00	121916760.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-22092176.26	-24433440.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	243883900.00	259883900.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-66976454.51	-107135288.85
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4558900.00	4558900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3037753.84	-3599733.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2047866.00	2227866.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1241774.71	-1421526.41
39214	Бусад үндсэн хөрөнгө	1672733252.00	3279988053.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-290012066.18	-490601910.66
39216	Дуусаагүй барилга, байгууламж	1018725558.00	
39217	Ном		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2747837649.50</u>	<u>3080971671.47</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2747837649.50</u>	<u>3080971671.47</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2747837649.50	3080971671.47

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	882335412.00	882335412.00
51101	Өмч: - төрийн	882335412.00	882335412.00
512	Хуримтлагдсан үр дүн	1848623737.50	2181757759.47
51210	Өмнөх үеийн үр дүн	1848623737.50	1848623737.50
51220	Тайлант үеийн үр дүн		333134021.97
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16878500.00	16878500.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2747837649.50</u>	<u>3080971671.47</u>

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1345721759.00	815613668.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12575000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	12575000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12575000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2000000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10575000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1333146759.00	815613668.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	52824000.00	14140000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52824000.00	14140000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1279274943.00	801473668.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	232999400.00	236883200.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	1046275543.00	564590468.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1047816.00	0.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1047816.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	412459851.07	482479646.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	412459851.07	482479646.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394986828.07	470672526.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	150542100.00	148507418.00
210101	Үндсэн цалин	124672100.00	128717950.00
210102	Нэмэгдэл	22270000.00	7798668.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3600000.00	2258748.00
210104	Урамшуулал		9732052.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19054500.00	14723782.00
210201	Тэтгэврийн даатгал	19054500.00	14723782.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31678456.00	32256192.00

210301	Гэрэл, цахилгаан	31678456.00	32256192.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9513505.80	7921200.00
210401	Бичиг хэрэг	356900.00	360700.00
210402	Тээвэр, шатахуун	6584160.00	5798000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	189600.00	153000.00
210404	Ном, хэвлэл	59045.80	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2323800.00	1609500.00
2105	Нормативт зардал	976600.00	1669500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	976600.00	1669500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1119065.00	3734480.00
210604	Урсгал засвар	1119065.00	3734480.00
2107	Томилолт, зочны зардал	456400.00	181600.00
210702	Дотоод албан томилолт	456400.00	181600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14409628.96	9143480.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14216003.96	8523980.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120000.00	120000.00
210803	Даатгалын үйлчилгээ		270000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	73625.00	180000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		49500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	167236572.31	252534874.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1206350.00	8703200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	166030222.31	243831674.03
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17473023.00	11807120.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4750716.00	11052000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1047816.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3212900.00	10352000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	490000.00	700000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12722307.00	755120.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12722307.00	755120.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	933261907.93	333134021.97
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	933261907.93	333134021.97

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	288871216.00	251023200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2000000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	2000000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2000000.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2000000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	286871216.00	251023200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	52824000.00	14140000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52824000.00	14140000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	232999400.00	236883200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	232999400.00	236883200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1047816.00	0.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1047816.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	288521845.76	250843200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	288521845.76	250843200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	271048822.76	239036080.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	150542100.00	147055200.00
210101	Үндсэн цалин	125122100.00	126504200.00
210102	Нэмэгдэл	21820000.00	8441100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3600000.00	2200000.00
210105	Гэрээт ажлын хөлс		9909900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19054500.00	16176000.00
210201	Тэтгэврийн даатгал	19054500.00	16176000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35505098.00	38700000.00
210301	Гэрэл, цахилгаан	35505098.00	38700000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7714370.80	7254000.00
210401	Бичиг хэрэг	73280.00	130300.00
210402	Тээвэр, шатахуун	6082360.00	5302400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	189600.00	187000.00
210404	Ном, хэвлэл	74330.80	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1294800.00	1634300.00
2105	Нормативт зардал	819200.00	1600000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		

210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	819200.00	1600000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	776140.00	6959100.00
210604	Урсгал засвар	776140.00	6959100.00
2107	Томилолт, зочны зардал	487560.00	439100.00
210702	Дотоод албан томилолт	487560.00	439100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54619003.96	11592680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54425378.96	10973180.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120000.00	120000.00
210803	Даатгалын үйлчилгээ		270000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	73625.00	180000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		49500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1530850.00	9260000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1530850.00	9260000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17473023.00	11807120.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4750716.00	11052000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1047816.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3212900.00	10352000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	490000.00	700000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12722307.00	755120.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12722307.00	755120.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	349370.24	180000.00
140008	Хүлээн авсан ногдол ашиг		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	350000.00	180000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	350000.00	180000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	350000.00	180000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	350000.00	180000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-350000.00	-180000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-629.76	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	629.76	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТ ТАЙЛАН

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	882,335,412.00	16,878,500.00	1,848,623,737.50	0.00	2,747,837,649.50
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	882,335,412.00	16,878,500.00	1,848,623,737.50	0.00	2,747,837,649.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	882,335,412.00	16,878,500.00	1,848,623,737.50	0.00	2,747,837,649.50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			333,134,021.97		333,134,021.97
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	882,335,412.00	16,878,500.00	2,181,757,759.47	0.00	3,080,971,671.47

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	236883200.00	236308080.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	236883200.00	236308080.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	225831200.00	225256080.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	147055200.00	147055200.00
210101	Үндсэн цалин	127805100.00	126504200.00
210102	Нэмэгдэл	8441100.00	8441100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1800000.00	2200000.00
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс	9009000.00	9909900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16176000.00	16176000.00
210201	Тэтгэврийн даатгал	10293800.00	16176000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1176400.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1470600.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	294100.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	2941100.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44700000.00	38700000.00
210301	Гэрэл, цахилгаан	44700000.00	38700000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7272400.00	7254000.00
210401	Бичиг хэрэг	130300.00	130300.00
210402	Тээвэр, шатахуун	5302400.00	5302400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	187000.00	187000.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1652700.00	1634300.00
2105	Нормативт зардал	1600000.00	1600000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1600000.00	1600000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1139100.00	7139100.00
210604	Урсгал засвар	1139100.00	7139100.00
2107	Томилолт, зочны зардал	448500.00	439100.00
210702	Дотоод албан томилолт	448500.00	439100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7440000.00	6892680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6820000.00	6273180.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120000.00	120000.00
210803	Даатгалын үйлчилгээ	270000.00	270000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180000.00	180000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50000.00	49500.00
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11052000.00	11052000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11052000.00	11052000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10352000.00	10352000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700000.00	700000.00

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	236883200.00	236128080.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	236883200.00	236128080.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	236883200.00	236128080.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		629.76
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	25.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	3.00	7.00
620003	Үйлчлэх ажилтан	18.00	14.00
620004	Гэрээт ажилтан		3.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22.0	25.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	22.00	22.00
650010	Гэрээт ажилтан		3

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.НАЗГҮЛ

Огноо: 2017.02.16